



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/148

Улаанбаатар хот

Технологийн хамгаалалт ажилд оруулах болон  
салгах, шалгах журмыг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан “Технологийн хамгаалалт ажилд оруулах болон салгах, шалгах журам”-ыг хавсралтаар шинэчлэн батласугай.

2.Батлагдсан журмыг нийт ажилтнуудад танилцуулан, мөрдөж ажиллахыг цех, хэсгийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын хэлтэс (П.Зоригоо)-т даалгасугай.

4.Энэхүү тушаалыг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Ерөнхий инженер (Э.Мөнхжаргал), цех, хэсэг, нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ

## ТЕХНОЛОГИЙН ХАМГААЛАЛТ АЖИЛД ОРУУЛАХ БОЛОН САЛГАХ, ШАЛГАХ ЖУРАМ

### НЭГ. ЗОРИЛГО

1.1. Энэхүү журам нь “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжийн хориг хамгаалалт тавих болон түүнийг салгах, шалгах ажиллагааг зохицуулахад чиглэгдэнэ.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Станцын үндсэн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хянах хэмжүүр, анхдагч датчик, мэдрэгч, аваарийн тросс, хориг хамгаалалт, тэдгээрийн программ хангамж бүхэлдээ харьяалагдана. Хавсралт №1-т заагдсан бүх тоноглол харьяалагдана.

### ГУРАВ. ХОРИГ, ХАМГААЛАЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1. Удирдлагын системийн байгууламжуудыг бүрэн бүтэн, цэвэр үзэмжтэй байлгах асуудлыг, тухайн хяналт удирдлагын хэрэгсэл суурилуулагдсан цех, хэсгийн шуурхай ажиллагааны хүмүүс хариуцна.
- 3.2. Удирдлагын төв (серверийн өрөө) болон тооцоолон бодох техник хэрэгсэл суурилуулагдсан байрны температур 25°C, чийглэг 40-80%-иас ихгүй байна.
- 3.3. Хориг, хамгаалалтын импульсийн шугам нь үлээлт гойжилтгүй нягт байх ёстой. Тоноглолын их засварын дараа бүх импульсийн шугамыг үлээлгэх хэрэгтэй. Агаар, хаг хусам орж болох импульсийн шугамыг графикайн дагуу тогтмол үлээлгэх хэрэгтэй.
- 3.4. Технологийн хамгаалалт болон хэрэгсэлүүд (анхдагч хэмжигч хувьсгуурууд, датчик, холболтын цуглуулгууд, хэмжих багажууд, түлхүүр ба сэлгэн залгагчууд, импульсийн шугам, хаалт г:м) нь өөрсдийн гадаад ялгах тэмдэгтэй байна.
- 3.5. Хамгаалалтын ар, өвөр талд болон суурилагдсан аппаратууд нь тэдгээрийн зориулалтыг тодорхойлсон хаягтай байх ёстой.
- 3.6. Хориг, хамгаалалтын анхдагч датчик, хэмжүүр дээр хамгаалалт ажиллах тавилыг тэмдэглэсэн байна.
- 3.7. Тоноглолыг зогсоох үйлчилгээтэй технологийн хамгаалалт нь ажилласан анхны шалтгааныг мэдээлж үлдээх төхөөрөмжтэй байх ёстой.
- 3.8. Хамгаалалт ажилласан анхны шалтгааныг мэдээлж үлдээх төхөөрөмж нь болсон үйл явцыг бүртгэн бичигч хэрэгсэл нь тухайн тоноглол ажиллаж байх хугацаанд тасралтгүй ажиллагаанд байх ёстой.

## ДӨРӨВ. ХОРИГ ХАМГААЛАЛТ ШАЛГАХ, АЖИЛД ОРУУЛАХ

- 4.1.Тухайн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс гаргасан ашиглалтын зааварт хамгаалалт шалгах, тавих тухай тусгасан бол ашиглалтын зааврын дагуу хийгдэнэ. Тоноглолд өөрчлөлт оруулсан буюу үйлдвэрлэсэн зааврын өгөгдөхүүн байхгүй бол ажиллах хугацаа ба тавилыг туршилтын үндсэн дээр тогтоох хэрэгтэй.
- 4.2.Бэлтгэл тоноглолын автоматаар залгах, салгах төхөөрөмж болон хамгаалалтын системийн хэвийн байдлыг логик удирдлагыг хариуцагч инженер (ТУСПИнженер)-тэй хамтран, тухайн тоноглолыг хариуцсан цехийн ашиглалтын инженер, ДХХА-н инженер нар шалгаж тухайн үед ээлжинд ажиллаж байгаа ээлжийн дарга, ДХХА-н засварчин нарт хүлээлгэн өгч хамгаалалт шалгах, салгах бүртгэлийн журнал (хавсралт №2) дээр тэмдэглэл хийж бүх оролцогч нарын гарын үсгээр баталгаажуулж шалгана.
- 4.3.Хориг, хамгаалалт болон автоматаар залгах төхөөрөмжийг дараах тохиолдолд заавал ажиллуулж шалгах ёстой. Үүнд:
- 3-аас дээш хоног зогссон тоноглолыг ажилд залгаж явуулах болсон.
  - Тоноглол нь 3-аас доош хоног зогссон боловч, энэ хугацаанд хамгаалалтын хэлхээнд нь өөрчлөлт, засвар үйлчилгээ хийгдсэн.
- 4.4.Хориг, хамгаалалтын ажиллах чадварыг шалгах дараалал ба ажлын эзэлхүүний хөтөлбөрийг станцын Ерөнхий инженерээр батлуулж хөтөлбөрийн дагуу шалгана.
- 4.5.Хориг, хамгаалалтыг тухайн тоног төхөөрөмжийг хариуцан ажиллаж байгаа цех, хэсгийн ээлжийн дарга, техникч нар ээлж хүлээн авахдаа шалган шуурхай ажиллагааны журнал дээр тэмдэглэл хөтөлж байна. Хэрэв хориг, хамгаалалтыг шалгаж байх явцад хамгаалалтыг салгасан тохиолдолд өмнөх ээлжийн дарга, техникчээс хамгаалалт гаргасан шалгааныг тодруулж, ээлжийн инженерт мэдэгдэн яаралтай буцаан тавих арга хэмжээ авна.
- 4.6.Техник хяналтын инженер нь цех, хэсгийн тоног төхөөрөмжийн хориг хамгаалалтыг 7 хоног бүр шалгаж “Хориг, хамгаалалт гаргах захиалгын журнал”-д тэмдэглэл хийж ажиллана. Мөн тоног төхөөрөмжийн хамгаалалтыг шалтгаангүй ажиллагаанаас гаргасан тохиолдолд судлан бүртгэж, хориг хамгаалалтыг гаргасан ажилтан, албан хаагчид хариуцлага тооцно.

## ТАВ. ХОРИГ ХАМГААЛАЛТ САЛГАХ

- 5.1.Байнгын ашиглалтанд оруулсан технологийн хамгаалалт нь тухайн тоноглолын ажиллах хугацаанд тасралтгүй ажиллаж байх ёстой. Гэмтэлгүй технологийн хамгаалалтыг салгаж ажлаас гаргахыг хориглоно. Хамгаалалтыг дараах тохиолдлуудад салгаж ажлаас гаргаж болно. Үүнд:
- А. Тухайн тоноглолын шилжилтийн горимд ажиллах үед тоноглолд гэмтэл учруулахгүй гэж тооцож байвал.
- Б. Тухайн тоноглолын ажиллагаанаас үл хамааран хамгаалалтын систем нь доголдож хэвийн бус байдал мэдэгдэж байвал, станцын Ерөнхий инженерт мэдэгдэж зөвшөөрөл авч, ээлжийн инженерийн шийдвэрээр салгана. Хэрэв Ерөнхий инженерээс зөвшөөрөл авах боломжгүй тохиолдолд технологийн хамгаалалтыг зайлшгүй салгах шаардлага гарвал

ээлжийн инженерийн шийдвэрээр салгана. Энэ тухай шуурхай ажиллагааны болон хамгаалалт шалгах, салгах бүртгэлийн журналд тэмдэглэл хийж үлдээнэ.

В. Станцын Ерөнхий инженерийн баталсан графикийн дагуу үзлэг шалгалт хийхэд.

Г. Хориг, хамгаалалтын анхдагч датчик, мэдрэгч, хэмжүүр илт алдаатай зааж байгаа нь тогтоогдвол.

Д. Үйлдвэрлэлийн процест нөлөөлөх тоноглолоос бусад тоноглолын хориг, хамгаалалтыг салгахдаа станцын ээлжийн инженерийн зөвшөөрлөөр салгаж ажилд орж болно.

5.2.Хориг, хамгаалалт салгахдаа хамгаалалт шалгах, салгах бүртгэлийн журналд бүртгэл хийж баталгаажуулах ёстой.

### **ЗУРГАА. ХОРИГЛОХ ЗҮЙЛС**

6.1.Хориг, хамгаалалтын хэмжилтийн, хүчний ба удирдлагын хэлхээг нэг кабелийн трассаар дамжуулахыг хориглоно.

6.2.Ажиллагаанд байгаа тоноглолын хориг хамгаалалтын тоног төхөөрөмж, хэлхээнд засвар, тохируулга хийхийг хориглоно.

6.3.Технологийн хамгаалалтыг шинэчлэн өөрчилсөнөөс бусад шалтгаанаар ашиглалтаас гаргаж, тухайн тоноглолыг хамгаалалтгүй ажиллуулахыг хориглоно.

6.4.Ажиллаж байгаа тоноглолын логик удирдлагын хэрэгслийн гадаад хэлхээ, модуль, PLC-д засвар, тохируулгын ажил хийхийг хориглоно.

Технологийн хамгаалалт ажилд оруулах болон салгах,  
шалгах журмын нэгдүгээр хавсралт

1. QXF-116/1.6/130/70 маркийн усан халаалтын зуух болон түүний туслах тоноглолын хамгаалалт.
2. Сүлжээний усны насосны даралтын хамгаалалт.
3. Өндөр даралттай хийгээр үлээлгэх бага даралттай урт даавуун ууттай үнс баригч төхөөрөмжийн хамгаалалт.
4. Түлш дамжлага №1А, 2А, 3АБ, 4АБ, 5АБ, 6А, 7А-ын аваарийн тросс, буух хоолойн бөглөрөлт, хоорондын хориг хамгаалалт.
5. Нэгдсэн цех, Хими хэсгийн 50м<sup>3</sup>, 100м<sup>3</sup>, 200м<sup>3</sup>-н бакнуудын түвшин багасалтын хамгаалалт.



Технологийн хамгаалалт ажилд оруулах болон салгах,  
шалгах журмын гуравдугаар хавсралт

№	Тоноглолын нэр	Анхааруулах дохио, Хамгаалалтын тавил	Төлөв	Технологийн хамгаалалт салгасан огноо /Он, сар, өдөр, цаг, минут/	Технологийн хамгаалалт салгасан шалтгаан	Технологийн хамгаалалт залгасан огноо /Он, сар, өдөр, цаг, минут/	Ерөнхий инженерийн зөвшөөрөл